



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 08 сарын 06 өдөр

Дугаар A/42

Улаанбаатар хот

Хан-Уул эрүүл мэндийн төвийн
хүний нөөцийг хөгжүүлэх
бодлого батлах тухай

Хан-Уул эрүүл мэндийн төвийн Удирдлагын багийн 2015 оны 07 сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2015-2019 онд хөгжүүлэх бодлого”-ыг нэгдүгээр хавсралтаар, уг бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2015-2019 онд хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланд дүгнэлт хийж, Удирдлагын багийн хуралд хагас, бүтэн жилээр танилцуулж, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллахыг хүний нөөцийн менежер /Б.Нямцэвэл/, сувилахуйн албаны дарга /Д.Оюунгэрэл/ нарт үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Б.Оюунгэрэл/, чанарын албаны дарга /Б.Чимгээ/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Т.ПҮРЭВЧУЛУУН

Хан-уул эрүүл мэндийн төвийн даргын
2015 оны 08 сарын 06 -ны өдрийн
А/42 дугаар тушаалын 1 хавсралт



ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ 2015-2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Нэг. Удиртгал

1.1. Ерөнхий мэдээлэл

Хан-Уул дүүрэг нь Улаанбаатар хотын томоохон дүүргийн нэг бөгөөд нийт амын тоо 160000 хүрч агаарын бохирдол, цаг агаарын эрс тэс уур амьсгал, дэд бүтцийн хөгжил, хог хаягдал, утаа, хувь хүний орлогын хэмжээ, стресс зэргээс шалтгаалан хүн амын дунд хоол боловсруулах эрхтэн, амьсгал, цусны эргэлт, мэдрэл, шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл, халдварт болон халдварт бус өвчлөл сүүлийн 5 жилүүдэд тогтвортой нэмэгдэж байна.

Энэ нь эмнэлгийн мэргэжилтнийг чадваржуулах, хүрэлцээг нэмэгдүүлэх хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг тусламж үйлчилгээг өргөжүүлэхийг улам бүр шаардах боллоо.

Хан-Уул эрүүл мэндийн төв нь нийт 229 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагаас их эмч 84, эм зүйч 2, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 85, удирдах болон бусад туслах ажилтан - 58 тус тус ажиллаж байна.

1.2 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлаж буй бодлого:

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэлүүд “Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогод тус тус тусгагдан хэрэгжиж байна.

- Монгол улсын Мянганы хөгжлийн зорилт, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын Эрүүл мэндийн хөгжлийн бодлогод эрүүл мэндийн хүний нөөцийн хөгжлийн зорилт тусгагдаж, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, сургалтыг олон улсын жишигт хүргэх, тэдний цалин урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, үйлчлүүлэгч

төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, хүний нөөцийн хуваарилалтыг зохистой болгох асуудлууд багтсан.

- Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Анагаахын боловсрол олгох, мэргэшил дээшлүүлэх, нарийн мэргэшлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох” талаар тусгагдсан
- Эрүүл мэндийн сайдын 2009 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого”-д Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, анагаах ухааны боловсрол олгох тогтолцоог боловсронгуй болгох, салбарын ажиллагсадын ажлын таатай аюулгүй орчин бүрдүүлэх, цалингийн тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн ажилтануудын хариуцлага, ёс зүйг нэмэгдүүлэх талаар тусгасан.
- Хан-Уул эрүүл мэндийн төвийн Хөгжлийн хөтөлбөрт хүний нөөцийн өнөөгийн болон хэтийн эрэлт хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж хэрэгжүүлэх, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажилтнуудыг хариуцлагын даатгалд хамруулах гэж тусгасан.

1.3 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхтэй холбоотой хэрэгжиж буй эрх зүйн голлох баримтууд:

Монгол улсын хууль:

- Эрүүл мэндийн тухай хууль: Тус хуульд эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн ажилтанд олгох нэмэгдэл, цалин хөлс, нөхөн төлбөрийн чиглэлээр тусгагдсан
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

Монгол улсын Засгийн газрын тогтоол:

- Монгол улсын Засгийн газрын 1995 оны “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай” 96 дугаар тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 1995 оны “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” батлах тухай 218 дугаар тогтоол
- Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл мөнгөн урамшуулал олгох журам - Монгол улсын Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоол
- Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл хөлс олгох журам -Монгол улсын Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох тухай Монгол улсын Засгийн газрын 2010 оны 108 дугаар тогтоол

Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан бодлого, шийдвэрүүд:

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого - Эрүүл мэндийн сайдын 2009 оны 444 дүгээр тушаал
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох журам - Эрүүл мэндийн сайдын 2013 оны 68 дугаар тушаал
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох журам - Эрүүл мэндийн сайдын 2014 оны 306 дугаар тушаал
- Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшүүлэх, төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлэх сургалтын индекс - Эрүүл мэндийн сайдын 2011 оны 73 дугаар тушаал
- Төгсөлтийн дараах давтан сургалтыг санхүүжүүлэх журам – Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2011 оны 423/249 дүгээр тушаал
- Их эмч, эм зүйчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2012 оны 182 дугаар тушаал
- Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлах тухай – Эрүүл мэндийн сайдын 2012 оны 183 дугаар тушаал
- Зарим эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт батлах тухай - 2011 оны 67 дугаар тушаал

- Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн загвар, зураглалыг шинэчлэн батлах тухай - Эрүүл мэндийн сайдын 2012 оны 168 дугаар тушаал

Хоёр. Өнөөгийн байдал:

2.1. Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн хангалт, байршил, шилжилт, хөдөлгөөн:

Хан-Уул эрүүл мэндийн төв нь нийт 229 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагаас их эмч 84, эм зүйч 2, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 85, удирдах болон бусад туслах ажилтан - 58 тус тус ажиллаж байгаа нь 2014 онд шинээр батлагдсан орон тооны стандарттай харьцуулахад хангалт 70%-тай байна. Нийт эмч мэргэжилтний 88% нь эмэгтэй, 12% нь эрэгтэй ажилтан ажиллаж байна. Боловсролын зэргийн байдлаар авч үзвэл 0,8% буюу 19 нь магистр, 42% нь буюу 94 бакалавр, 34% нь буюу 77 дипломи, 23% нь буюу 31 хүн бүрэн дунд боловсролтой бөгөөд нийт, ажилтны 49 буюу 22% нь 0-4 жил ажилласан, 39 буюу 17% нь 5-12 жил, 14 буюу 0,6% нь 13-16 жил, 56 буюу 25% нь 17-24 жил, 63 буюу 28% нь 25 жилээс жил ажилласан байна. Мөн нийт эмч, мэргэжилтний 20% нь мэргэжлийн зэрэгтэй байна. Үүнээс мэргэжлийн зэрэгтэй их эмчийн эзлэх хувь 27%, сувилагч тусгай мэргэжилтний эзлэх хувь 24% байна.

Нийслэлийн эрүүл мэндийн газраас батлагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтнуудын орон тооны хувьд үндсэндээ хангагдсан. Гэвч Нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтаар ажиллахад зарим нарийн мэргэжлийн эмч дутагдалтай байна.

Яаралтай тусламж - эрчимт эмчилгээ, дотор, уушиг, эх барих эмэгтэйчүүд, сувилагч зэрэг мэргэжилтнүүд шаардлагатай хэвээр байна.

90,000 хүн амд үйлчлэх хүчин чадал бүхий орон тоогоор 140,000 гаруй хүн ам болон эмчлүүлэгсдийн тоо жил дараалан нэмэгдэж, ачаалал ихэссэн болон зарим шинэ ажил үйлчилгээтэй холбоотойгоор нэмэгдсэн орон тоогоор ажиллах шаардлага урган гарч байна. Гэвч жил жилийн цалингийн сан хүрэлцэхгүйн улмаас эмч мэргэжилтэнд олгох урамшуулал, ур чадварын нэмэгдлийг олгоход хүндрэлтэй байна. Цалин, урамшуулал бага байгаа нь эмч мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллахад нөлөөлж байгаа.

Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах болон давтан сургах, чадваржуулах бодлого хангалтгүй, бие даан суралцах хүсэл эрмэлзлэл сул, сургалтын үйл явц нь кредит олгохоос хэтрэхгүй байна.

Эмч, эмнэлгийн ажилтны ажлын хариуцлага сахилга, харилцаа хандлагын байдал өнөөгийн тавигдаж байгаа зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

2015 оны эхний 7 сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаагаар ажиллаж байгаа болон дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо:

№	Албан Тушаал	Стандарт орон тоо	Одоо ажиллаж байгаа	Дутагдалтай байгаа	Тайлбар
Амбулатори					
1	Арьсны өвчин судлалын эмч	2	1	1	
2	Арьсны өвчин судлалын сувилагч	2		2	
3	БЗДХ/ХДХВ/ДОХ-ын эмч	3	2	1	
4	БЗДХ/ХДХВ/ДОХ-ын сувилагч	3	2	1	
5	Гэмтэл согог заслын эмч	3	2	1	
6	Гэмтэл согог заслын сувилагч	3	2	1	
7	Дотрын эмч: Үүнээс				
	Дотрын сувилагч	7	1	6	
	Бөөрний эмч	1	1		
	Дотоод шүүрлийн эмч	1	1		
	Зүрх судасны эмч	2	3		
	Уушигны эмч	1		1	
8	Дүрс оношлогооны эмч: Үүнээс				
	Дурангийн эмч	1	1		
	Дурангийн сувилагч	1	1		
	Рентгений эмч	2	2		
	Рентген техникч	3	3		
	Хэт авиа оношлогооны эмч	3	3		
	Хэт авиа оношлогооны сувилагч	3		3	
9	Лабораторийн эмч	4	3		
10	Мэдрэлийн эмч	4	2	2	
11	Мэдрэлийн сувилагч	4	2	2	
12	Мэс заслын эмч	3	2	1	
13	Мэс заслын сувилагч	3	2	1	
14	Тархвар судлаач	2	2		
15	Настны эмч	2	1		
16	Настны сувилагч	2	1		
17	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн	1		1	

18	Нүдний эмч	2	2		
19	Нүдний сувилагч	2	2		
20	Нүүр амны эмч / Шүдний эмч/	6	6		
21	Нүүр амны сувилагч / Шүдний сувилагч/	6	6		
22	Сэргээн засах эмчилгээний эмч	4	3	1	
23	Сүрьеэгийн эмч	3	3		
24	Сүрьеэгийн сувилагч	3	3		
25	Сэтгэц наркологийн эмч	2	2		
26	Сэтгэц наркологийн сувилагч	2	1		
27	Уламжлалтын эмч	3	1	2	
28	Хавдрын эмч, /Хөнгөвчлөх эмчилгээний эмч /	3	1	2	
29	Хавдрын сувилагч	3	1	2	
30	Халдвартын эмч	3	1	2	
31	Халдвартын сувилагч	3		3	
32	Харшил судлалын эмч	1		1	
33	Харшил судлалын сувилагч	1		1	
34	Хүүхдийн эмч	5	2	3	
35	Хүүхдийн сувилагч	5		5	
36	Өсвөр үеийн эмч	1	1		
37	Өсвөр үеийн сувилагч	1		1	
38	Хоол судлалын эмч	1	1		
39	Хоол судлалын сувилагч	1	1		
40	Хор судлаач эмч	1		1	
41	Чих хамар хоолойн эмч	4	2	2	
42	Чих хамар хоолойн сувилагч	4	2	2	
43	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	5	5		
44	Эх барих эмэгтэйчүүдийн сувилагч	5	4	1	
45	Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн эмч	1		1	
46	Эмэгтэйчүүдийн дотоод шүүрлийн сувилагч	1		1	
47	Цусны үйлдвэрлэлийн транофизиологич	1		1	
48	Эрэгтэйчүүдийн эмч	1		1	
49	Эрэгтэйчүүдийн сувилагч	1		1	
50	Эмгэг судлалын эмч	1		1	
51	Эмгэг судлалын туслах ажилтан	1		1	
52	Эс судлаач эмч	1		1	
53	Эмийн сангийн эрхлэгч	1	1		
54	Эм зүйч	1	1		
55	Эм найруулагч, эм олгогч	1	1		
56	Эрүүл мэндийн мэдээлэл зүйч / Статистикч эмч/	1	1		
57	Статистикч бага эмч	3	2	1	
58	Хавдар бүртгэгч	1	1		
59	Яаралтай тусламжийн эмч / Хүүхдийн түргэний эмч	4	7		
		166	104	62	

Хэвтэн эмчлүүлэх тасаг					
60	Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч	1	1		
61	Хэвтэн эмчлүүлэх тасгийн ахлагч сувилагч	1	1		
62	Дотрын их эмч	6	5	1	
63	Мэдрэлийн их эмч	2	2		
64	Хүлээн авах яаралтай тусламжийн эмч	4	3	1	
65	Эрчимт эмчилгээний сувилагч	1	1		
66	Хүлээн авахын сувилагч	4		4	
67	Ээлжийн сувилагч	15	15		
68	Цусны сувилагч	1	1		
69	Туслах сувилагч	6		6	
70	Асрагч	6	6		
		47	35	12	
Бусад сувилагч, тусгай мэргэжилтэн					
71	Сувилахуйн арга зүйч	1	1		
72	Поликлиникийн тасгийн ахлах сувилагч	1		1	
73	Салбар амбулаторийн ахлах сувилагч	1	1		
74	Нийгмийн эрүүл мэндийн тасгийн ахлах сувилагч	1		1	
75	Хүүхдийн түргэн тусламжийн дуудлагын сувилагч	4		4	
76	Сайн дурын зөвөлгөө шинжилгээний төвийн зөвөлгөө өгөх сувилагч	1	1		
77	Ахуй засалч	1		1	
78	Ээлжийн лаборант	4		4	
79	Цусны банканд ажиллах	1		1	
80	Клиник лаборант	3	8		
81	Биохимийн лаборант	2			
82	Иммунологи, серологийн лаборант	2			
83	Бактерлог лаборант	2			
84	Цитологи, гистологийн лаборант	2			
85	Сүрьеэгийн лаборант	1	1		
86	Нүүр амны эрүүл ауйч	2		2	
87	Зүү төөнүүрийн сувилагч	1		1	
88	Усан эмчилгээний сувилагч	1	1		
89	Хөдөлгөөн засалч	3	1	2	
90	Парафин эмчилгээний сувилагч	1	1		
91	Физик эмчилгээний сувилагч	2	2		
92	Сэргээн засах эмчилгээний сувилагч	2	2		
93	Сэргээн засах -Татлага эмчилгээний сувилагч	1	1		
94	Биеийн тамирын арга зүйч	1	1		
95	Цус сэлбэлтийн сувилагч	2		2	
96	Хоол засалч	1		1	
97	Шүдний техникч	1		1	
98	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч	1		1	
		46	21	22	

Бусад ажилтан					
99	Нийгмийн ажилтан	1		1	
100	Ёс зүйн ажилтан - эвлэрүүлэн зуучлагч	1		1	
101	Сэтгэл засалч	1	1		
102	Хөдөлмөрийн эрүүл ахуйч	1		1	
		4	1	3	
Дэмжих хангамж үйлчилгээний ажилтан					
103	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга, ахлах инженер	1		1	
104	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	1		1	
105	Компьютер томографийн оператор	1		1	
106	Мэдээллийн технологийн албаны дарга	1		1	
107	Телемедициний үйлчилгээний менежер	1		1	
108	Сүлжээний аюулгүй байдал хариуцсан инженер	1	1		
109	Өгөгдлийн сангийн аюулгүй байдал хариуцсан инженер	1	1		
110	Программ хангамж хариуцсан инженер	1		1	
111	Угаалгын тасгийн дарга	1		1	
112	Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн дарга	1		1	
113	Ариутгагч	3	3		
114	Ариун материал бэлтгэгч	1		1	
115	Угаагч	2	2		
116	Хоол үйлдвэрлэлийн тасгийн дарга	1		1	
117	Тогооч, туслах тогооч, бэлтгэгч, хоол зөөгч	Үйл ажиллагаанаас хамаарах			
		17	7	10	
Бусад орон тоо					
Удирдлага					
119	Дарга	1	1		
120	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	1	1		
121	Стратеги төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга	1		1	
122	Гадаад харилцаа, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан захирал	1		1	
123	Гадаад харилцаа, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан менежер	1		1	
124	Гадаад харилцаа, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан туслах ажилтан	1		1	
125	Даргын туслах	1			
126	Хүний нөөцийн албаны дарга	1			
127	Хүний нөөцийн мэргэжилтэн	1	1	1	
128	Хүний нөөцийн туслах ажилтан	1		1	
129	Сувилахуйн албаны дарга	1	1		
130	Чанарын албаны дарга, менежер	2	2		
131	Лабораторийн чанарын менежер	1	1		
132	Хуулийн зөвлөх	1			
133	Поликлиникийн тасгийн эрхлэгч	1	1		
134	Салбар амбулаторийн эрхлэгч	1	1		

135	Нийгмийн эрүүл мэндийн тасгийн эрхлэгч	1	1		
		18	10	6	
Эдийн засаг, санхүү					
136	Санхүүгийн албаны дарга	1		1	
137	Эрүүл мэндийн эдийн засагч	1	1		
138	Даатгал хариуцсан эмч	1	1		
139	Даатгалын ажилтан	1	1		
140	Нягтлан бодогч	1	1		
141	Тооцооны болон бусад нягтлан бодогч	1	1		
142	Нярав	3	3		
		9	8	1	
Лавалгаа үйлчилгээ, бичиг хэрэг					
143	Цахим мэдээллийн эмнэлзүйн менежер эмч	1		1	
144	Цахим бүртгэгч	1	1		
145	Архив бичиг хэргийн ажилтан	1	1		
146	Номын сангийн ажилтан	1		1	
147	Лавалгаа үйлчилгээний ажилтан	1		1	
148	Угтах үйлчилгээ	1	1		
		6	3	3	
Мэдээлэл технологи					
149	Мэдээллийн албаны дарга	1		1	
150	Компьютерийн сүлжээний инженер	1		1	
151	Цахим хуудасны график инженер	1		1	
152	Программ хангамж хариуцсан инженер	1		1	
153	Хэвлэлийн хэсгийн ажилтан	1		1	
		5	0	5	
Хангамж, үйлчилгээ					
154	Хамгамжийн албаны дарга	1	1		
155	Сантехникийн инженер	1		1	
156	Цахилгааны инженер	1		1	
157	Цахилгааны техникч, механик	1		1	
158	Димпетчер	1		1	
159	Слесарь	6	6		
160	Лифтчин	1		1	
161	Сантехник				
162	Цахилгаанчин	1	1		
163	Үйлчлэгч	16	16		
164	Жолооч	6	6		
165	Өлгүүрчин	2	2		
166	Мужаан	1	1		
		38	33	5	
Нийт орон тооны харьцаа		356	222	129	
Стандартад тусгагдаагүй боловч одоогийн бүтэцэд байгаа албан тушаал					
	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга		1		
1	Өдрийн эмчилгээний эмч		1		

3	Тарианы сувилагч		1		
4	Өрхийн менежер		1		
5	Сургалт арга зүйн эмч		2		
6	Вакционатор сувилагч		1		
7	БЗДХ/ХДХВ/ДОХ-ын лаборант		1		
			7		
Нийт			229		

2.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгаа, цалин хөлс, урамшуулал:

Эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн салбарт ажиллагсадын нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож байна

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 26 эрүүл мэндийн ажилтан 6-8 %-ийн хүүтэй орон сууцны зээлд, 100000 айл орон сууц хөтөлбөрт 6, Улаанбаатар орон сууц сангаас төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт 2 эрүүл мэндийн ажилтан хамрагдаад байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал, байгууллагын Хамтын гэрээ болон бусад хууль, тогтоол, журамд заасны дагуу дараах дэмжлэгийг үзүүллээ.

- Эмч мэргэжилтнийг цалингийн хувиар урамшуулахад 581 хүнд 785,748,400₮
- Гадаадад суралцах зардлаар урамшуулах 5 хүнд 4,600,000₮,
- Дотоодод суралцах зардлаар урамшуулах 51 хүнд 7096700₮,
- Мөнгөн шагнал 378 хүнд 25, 681,400₮
- Унаа хоолны нэмэгдэл 920 хүнд 451,220,026₮
- Мэргэжлийн зэргийн нэмэгдэл 189 хүнд 96,675,000₮
- Байгууллагын дотоод журам, Хамтын гэрээний заалтын дагуу олгосон мөнгө тусламж 777 хүнд 182,494,495₮

2.3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй:

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг мөрдүүлж, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, улмаар хүн амд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилго бүхий “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо” нь 2014 онд шинэчлэгдэн ажиллаж байна.

Хэдийгээр түвшин бүрт эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч ёс зүй нь эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал хэвээр байна.

Сүүлийн 3 жилд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон чанарын албанд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийж үзэхэд 50% нь эмнэлгийн мэргэжилтнүүдийн харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой өргөдлүүд ирж байна.

Гурав. Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг хөгжүүлэх бодлого:

3.1. Зорилго, зорилт :

Зорилго: Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд хувь хүний оролцоог байгууллагын дэмжлэгтэй хослуулж хүний нөөцийн чадвахыг дээшлүүлэх, мэргэшсэн өндөр ур чадвар бүхий эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад шаардагдах нийгмийн баталгааг хангаж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшлийг сайжруулснаар иргэдэд хүргэж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Зорилт-1:

Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалт, богино хугацааны сургалтуудад хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд хувь хүний оролцоог байгууллагын дэмжлэгтэй хослуулж хүний нөөцийн чадвахыг бэхжүүлж нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Зорилт-2:

Эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдээр тасралтгүй хангах талаар төлөвлөлт боловсруулан ажиллана.

Зорилт-3:

Эрүүл мэндийн ажилтануудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэхүйц дэмжлэгт орчин бүрдүүлнэ

Зорилт-4:

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлагыг нэмэгдүүлнэ

3.2. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл: Үүнд:

1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Эмч, мэргэжилтэн бүрээр карер өсөлтийн зураглал боловсруулан хэрэгжүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах давтан сургалтанд хамруулах дунд хугацааны төлөвлөлт /5 жил/-ийг батлуулан хэрэгжүүлэх
- Төгсөлтийн дараах давтан сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэн, хяналт тавин ажиллах
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийг богино хугацааны болон нэмэлт ур чадвар олгох сургалтуудад суралцуулах
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийн гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагуудын удирдах ажилтануудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаадын улс орнуудад мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, боломж олгох

2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Ажиллагсдын хэрэгцээг тодорхойлж дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалтын 2019 он хүртэлх төлөвлөлтийг хэрэгжүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нөхцөл боломжийг бүрдүүлэхэд дүүргийн төр захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх

3-р зорилтын хүрээнд:

- Төрийн санхүүжилтээр 6 сараас дээш хугацаагаар суралцаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдэд дэмжлэг үзүүлэх
- Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Ажилтнуудыг хариуцлагын даатгалд хамруулах.
- Цалингийн болон бусад төрлийн зээлийн хөнгөлттэй нөхцөлд ажилтануудыг хамруулах талаар банкуудтай хамтран ажиллах
- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан орон сууц бариулах талаар нийслэл дүүргийн төр захиргааны удирдлагад уламжлан дэмжлэгт хамруулах

4-р зорилтын хүрээнд:

- Эрүүл мэндийн ажилтануудын ёс зүйн сургалтыг шинэлэг арга барилгаар зохион байгуулах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороонд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолд дүн шинжилгээг жил бүр хийж ажиллах, эрүүл мэндийн ажилтануудын ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр хяналт тавьж ажиллах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор *Хариуцлагын талон*-ны журам хэрэгжүүлж хяналт тавих

3.3 Хяналт шинжилгээ үнэлгээ:

Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2015-2019 онд хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцох, зохицуулалт болон дараагийн шатны төлөвлөлтийг хийх зорилгоор хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийнэ.

Бодлогын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг чанарын алба болон дотоод хяналтын алба гүйцэтгэнэ.

Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд:

№	Шалгуур үзүүлэлт	Одоогийн байгаа түвшин	2015 онд хүрэх түвшин	2016 онд хүрэх түвшин	2017 онд хүрэх түвшин	2018 онд хүрэх түвшин	2019 онд хүрэх түвшин	Эх сурвалж
<p><i>Зорилт-1: Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалт, богино хугацааны сургалтуудад хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд хувь хүний оролцоог байгууллагын дэмлэгтэй хослуулж хүний нөөцийн чадвахыг бэхжүүлж нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ</i></p>								
1	Шаардлагатай нарийн мэргэжил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний тоо	131	140	160	180	200	220	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулсан судалгаа
2	Төгсөлтийн дараах сургалтанд хамрагдах гэрээний дагуу тогтвор суурьшилтай ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний хувь	98	100	100	100	100	100	Хүний нөөцийн судалгаа, цалингийн карт, хөдөлмөрийн гэрээ, гэрээний дүгнэлт
3	Мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний хувь	20	20	22	27	29	31	Мэргэжлийн зэрэг олгосон Эрүүл мэндийн сайдын тушаал

4	Богино хугацааны болон нэмэлт ур чадвар олгох сургалтуудад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	325	385	400	450	519	575	Сургалтын бүртгэл, гэрчилгээ, зохион байгуулсан сургалтын тайлан
5	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлж TOEFL, IELTS-ийн шалгалтанд тэнцсэн эмнэлгийн мэргэжилтний тоо	0	0	1	2	3	4	TOEFL, IELTS-ийн шалгалтанд орж тэнцсэн талаарх бичиг баримт
6	Гадаад оронд мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх давтан сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	3	5	10	15	20	25	Сургалтын гэрчилгээ, диплом
<i>Зорилт-2: Эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдээр тасралтгүй хангах талаар төлөвлөлт боловсруулан ажиллана</i>								
7	Дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	1,390,000	1,600,000	1,800,000	2,000,000	2,200,000	2,500,000	Тайлан
8	Шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнээр хангагдсан хувь	60	62	65	68	70	75	Судалгаа, тайлан
<i>Зорилт-3: Эрүүл мэндийн ажилтануудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэхүйц дэмжлэгт орчин бүрдүүлнэ</i>								
9	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	30	50	70	80	100	Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

10	1 сараас дээш хугацааны сургалтанд суралцах хугацаандаа дэмжлэг авч байсан эмнэлгийн мэргэжилтний тоо	5	7	10	15	20	25	Цалингийн карт, дэмжлэг үзүүлсэн тушаал, судалгаа, тайлан
11	Цалингийн болон бусад хөнгөлттэй зээлд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	50	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Зээлийн гэрээ
12	Хөнгөлттэй нөхцлөөр орон сууцны зээлд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	2	4	6	8	10	12	Зээлийн гэрээ
<i>Зорилт-4: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлагыг нэмэгдүүлнэ</i>								
13	Ёс зүйн талаар зохион байгуулсан сургалтын тоо	1	3	5	6	7	8	Сургалтын удирдамж, төлөвлөгөө, тайлан, бүртгэл
14	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагын талаар иргэдээс ирүүлж буй өргөдлийн тоо	10	10	7	5	3	0	Өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн байдал
15	Эвлэрүүлэн зуучлагчийн хийсэн эвлэрүүлсэн арга хэмжээний тоо	1	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Тухай бүр	Эвлэрүүлэн зуучлагчийн ажлын тайлан, иргэдийн ярилцлага

Хяналт шинжилгээ үнэлгээнд энэхүү бодлогод тусгасан шалгуур үзүүлэлтүүдээс гадна хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, стратеги, хөтөлбөрийн үнэлгээнд ашиглагддаг бусад шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах боломжтой.

Хан-Уул эрүүл мэндийн төвийн хүний нөөцийг 2015-2019 онд хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хүний нөөцийн менежер, сувилахуйн алба хэрэгжүүлж, чанарын алба болон дотоод хяналтын алба хяналт тавина.

3.4 Бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилт:

- Улсын төсөв
- Олон улсын байгууллагын хандив, тусламж
- Бусад

Дөрөв. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ 2019 ОН ХҮРТЭЛХ ТӨЛӨВЛӨЛТ:

4.1. Үндсэн мэргэжил

№	Мэргэжил	Их эмч				
		2015	2016	2017	2018	2019
1	Харшил судлалын эмч			1		
2	Арьс судлалын эмч					1
3	Дотор /бөөр/	1		1		
4	Дотор /зүрх/					1
5	Эх барих, эмэгтэйчүүдийн эмч	1				1
6	Хүүхдийн эмч				1	
7	Нүдний эмч		1			
8	Халдвартын эмч				1	
9	Чих хамар хоолойн эмч			1		
10	Дүрс оношилгооний эмч	1		1		
11	Дурангийн эмч		1			
12	Мэс заслын эмч	1	1			
13	Гэмтлийн эмч			1		
14	Сүрьеэгийн эмч		1		1	
15	Шүдний эмч	1				
16	Хүүхдийн шүдний эмч			1		
17	Хөнгөвчлөх эмчилгээний эмч				1	
18	Хоол судлалын эмч					1
19	Эрэгтэйчүүдийн эмч				1	
20	Мэдрэлийн эмч	1				1
21	Эмгэг судлалын эмч					1
22	Эм зүйч					1

Дүн		6	4	6	5	7
№	Мэргэжил	Сувилагч тусгай мэргэжилтэн				
		2015	2016	2017	2018	2019
1	Эм найруулагч		1			
2	Шүдний сувилагч	1	1			
3	Эх барих бага эмч		1			
4	Лаборант			1		
5	Сүрьеэгийн сувилагч		1			
6	Хөдөлгөөн засалч		1			
7	Сэргээн засах эмчилгээний сувилагч					1
8	Бариа заслын сувилагч					1
9	Уламжлалтын сувилагч					1
10	Статистикч бага эмч		1			
11	Гэмтлийн сувилагч	1				
12	Туслах сувилагч	1	1	1	1	1
Дүн		3	7	2	1	4
Нийт дүн		9	11	8	6	11

4.2 Мэргэжил дээшлүүлэх

№	Мэргэжил	Их эмч				
		2015	2016	2017	2018	2019
1	Дотрын эмч			1		1
2	Тархины судасны доплерографи /мэдрэлийн эмч/	1	1			
3	Дүрс оношлогооны эмч		1			
4	Эх барих эмэгтэйчүүдийн эмч				1	
5	Бактерлогийн эмч	1				
6	Донтох өвчин судлал		1			
7	Сэргээн засах эмчилгээ	1			1	
8	Шүдний эмч	1		1		

9	Тархвар судлаач				1	
Дүн		4	3	2	3	1
№	Мэргэжил	Сувилагч тусгай мэргэжилтэн				
		2015	2016	2017	2018	2019
1	Лаборант			1		
2	Рентген техникч				1	
3	Ариутгагч		1			
4	Сувилагч	1	1	1	1	1
5	Шүдний сувилагч	1		1		1
Дүн		2	2	3	2	2
Нийт дүн		6	5	5	5	3

Хан-уул эрүүл мэндийн төвийн даргын
 2015 оны 08 сарын 06 -ны өдрийн
 А/44 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТТБ2350.А.9120262

**ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ 2015-2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
 АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /оноор/					Хамтран ажиллах	Зорилтод шаардагдах төсөв хөрөнгө
		2015	2016	2017	2018	2019		
<p><i>Зорилт-1: Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах сургалт, богино хугацааны сургалтуудад хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд хувь хүний оролцоог байгууллагын дэмлэгтэй хослуулж хүний нөөцийн чадаахыг бэхжүүлж нийт эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтнүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ</i></p>								
1.1	Хан-Уул Эрүүл мэндийн төвийн "Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зураглал"-ыг боловсруулах	+					Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, сувилахуйн албаны дарга	-
1.2	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах давтан сургалтанд хамруулах дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	+	+				Тасаг нэгжийн эрхлэгч	
1.3	Эмч, мэргэжилтэн бүрээс өөрийгөө хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө гаргуулан хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх	+	+	+	+	+	Ажилтан бүр	5000000
1.4	Сүүлийн 5-аас дээш жилд төгсөлтийн дараах давтан сургалтанд хамрагдаагүй эмнэлгийн мэргэжилтнүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, давтан сургалтанд хамруулах арга хэмжээ авах	+	+	+	+	+	Тасаг нэгжийн эрхлэгч	

1.5	Төгсөлтийн дараах сургалтанд хамрагдах гэрээний хугацаанд байгууллагад тогтвор сууршилтай ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдийн судалгааг гаргах, гэрээний хугацаа дуусахаас өмнө шилжсэн буюу ажлаас чөлөөлөгдсөн эмнэлгийн мэргэжилтнүүдээр суралцах хугацаанд төрөөс санхүүжүүлсэн хөрөнгийг буцааж төлүүлэх арга хэмжээ авах	+	+	+	+	+	+	+	Тасаг нэгжийн эрхлэгч, хуулийн зөвлөх	
1.6	Жил бүр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах шаардлагатай богино хугацааны сургалт зохион байгуулах төлөвлөлтийг хийж хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+	Тасаг нэгжийн эрхлэгч	1500000
1.7	Эмнэлгийн мэргэжилтнүүдээс англи хэлний түвшин тогтоох шалгалт авах, сургалтанд хамруулах	+	+	+	+	+	+	+	Англи хэлний сургалтын байгууллага	1000000
1.8	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг англи хэлний сургалтанд хамруулах, TOEFL, IELTS-ийн шалгалтанд тэнцэхэд дэмжлэг үзүүлэх	+	+	+	+	+	+	+	Англи хэлний сургалтын байгууллага	1000000
1.9	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэгтэй болгох талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	+	+	+	+	+	+	+	Мэргэжлийн холбоод	
1.10.	Эмнэлгийн мэргэжилтнийг гадаад оронд чадваржуулах сургалтанд хамруулах талаар Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн ИТХ, Засаг дарга, мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	+	+	+	+	+	+	+	НЭМГ, ХУДЗДТГ, ТББ	5000000
1.11	Гадаадын эмнэлэгт богино хугацаагаар ажиллуулж, ажлын байрны солилцох сургалтыг тогтмол зохион байгуулах	+	+	+	+	+	+	+	НЭМГ, ХУДЗДТГ, ТББ	2500000
1.12	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад хариуцлагатай албан тушаалнаас компьютерийн түвшин тогтоох шалгалт авч түвшингээр нь ангилан сургалт зохион байгуулах							+	Мэргэжлийн байгууллага	500000

1.13	Гадаад сургалтанд хамрагдсан ажилтан бүр байгууллагадаа шинэлэг санаа, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг туршлагыг нэвтрүүлж хэвших	+	+	+	+	+	+	+	+	+	+	Сургалтанд хамрагдсан хувь хүн
Зорилт- 2: Дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнүүдээр тасралтгүй хангах талаар төлөвлөлт боловсруулан ажиллана.												
2.1	Жил бүр дутагдалтай байгаа орон тооны судалгааг шинэчлэн гаргаж, орон тооны захиалгыг Анагаах ухааны боловсрол олгож буй сургуулиудад хүргүүлэх, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр ил тод нээлттэй байршуулах	+	+	+	+	+	+	+	+	+	250000	Анагаах ухааны их, дээд сургууль, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
2.2	Дутагдалтай байгаа орон тоог нөхөх, хүний нөөцөөр тасралтгүй хангах зорилгоор жил бүрийн төсөвт тусуулах саналаа Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэх	+	+	+	+	+	+	+	+	+	НЭМГ	
2.3	Жил бүр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх 2019 он хүртэлх төлөвлөлтийг хэрэгжүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	+	+	+	Хүний нөөцийн менежер	
2.4	Ажил идэвхитэй хайж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийг судалгаанд бүртгэх	+	+	+	+	+	+	+	+	+	Хүний нөөцийн менежер	
2.5	Удирдах ажилтныг удирдлага зохион байгуулалтын чиглэлээр сургалтанд хамруулах	+	+	+	+	+	+	+	+	+	1500000	Сургалтын байгууллага
2.6	Ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах, дадлагажуулах журмыг боловсруулж батлуулах	+	+	+	+	+	+	+	+	+	Хүний нөөцийн менежер	
Зорилт -3: Эрүүл мэндийн ажилтануудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах эрмэлзлийг нэмэгдүүлэхүйц дэмжлэгт орчин бүрдүүлнэ												
3.1	Хан-Уул эрүүл мэндийн төвийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх	+										Удирдлагын баг Тасаг нэгжийн эрхлэгч, хуулийн зөвлөх

3.2	Эрүүл мэндийн ажилтануудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт хамруулах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх	+	+	+	+	+	+	Ажилчдын эмч	
3.3	Урьдчилан сэргийлэх үзлэгээр 3 дахь шатлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт оношлогоо, эмчилгээ хийлгэх шаардлагатай эрүүл мэндийн ажилтануудын судалгаа гаргаж, оношлогоо, эмчилгээнд хамрагдахад нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч сэтгэл зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх	+	+	+	+	+	+	Ажилчдын эмч	
3.4	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулж төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт оношлогоо болон эмчилгээ хийлгэх хугацаанд цалинтай чөлөө олгох, байгууллагын санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан тусламж тэтгэмж олгох талаар заалт оруулах	+	+	+	+	+	+	Хуулийн зөвлөх	
3.5	“Шилдэг бүтээл”-ийн шагнал олгох журмын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн гаргах	+	+	+	+	+	+	Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, сувилахуйн албаны дарга	750000
3.6	Орон сууцны зээл болон түрээсийн орон сууцанд хөнгөлөлттэй хамруулах талаар дүүргийн удирдлагатай хамтран ажиллах хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргуулах	+	+	+	+	+	+	Ахлах нягтлан бодогч, Удирдлагын баг	
3.7	Цалингийн болон бусад төрлийн зээлийн хөнгөлттэй нөхцөлд ажилтануудыг хамруулах талаар банкуудтай хамтран ажиллах	+	+	+	+	+	+	Банкууд	
3.8	3 сараас дээш хугацаагаар мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцаж буй эмнэлгийн мэргэжилтнийг суралцах хугацаанд нь албан тушаалын үндсэн цалинг олгох	+	+	+	+	+	+	Ахлах нягтлан бодогч, Удирдлагын баг	

3.9	Эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх талаар дүүргийн удирдлагуудтай хамтран ажиллах	+	+	+	+	+	+	+	+	Дүүргийн удирдлага	
3.10.	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр боловсруулах									Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга	
3.11	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг хариуцлагын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах									Ахлах нягтлан бодогч, Удирдлагын баг	
3.12	Шинээр ажилд орсон, Гепатит В-ын халдвар аваагүй мэргэжилтэн бүрийг вакцинд хамруулж хэвших									Тархвар судлаач	
3.13	Байгууллагын ахмад ажилтнуудтай тогтмол уулзах, ахуй амьдралд нь дэмжлэг үзүүлэх, Дэлхийн эмч нарын өдрөөр тэдэнд зориулсан арга хэмжээ зохион байгуулж хэвших	+	+	+	+	+	+	+	+	Ахмадын эмч, тасаг нэгжийн эрхлэгч	2500000
3.14	Ажлын байрны стрессийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох									Сэтгэцийн кабинет, Удирдлагын баг	
3.15	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулах									Хүний нөөцийн менежер	
Зорилт 4: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлагыг нэмэгдүүлнэ											
4.1	Эрүүл мэндийн ажилтануудад зориулсан ёс зүйн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах								+	Ёс зүйн хэсгийн хороо	
4.2	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр үйлчилүүлэгчдээс санал асуулга авч нэгтгэн дүгнэж түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх								+	Ёс зүйн хэсгийн хороо	
4.3	Эмнэлгийн ажилтны өдрийг тохиолдуулан "Инээмсэглэн угтаж итгэл төрүүлэн үдье" ажлаа сурталчилах, эмч, ажилчдын хөдөлмөр алдар тэмдэглэх өдөрлөг зохион байгуулах								+	Ёс зүйн хэсгийн хороо	

4.4	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцааны ур чадварыг дээшлүүлэх сургалтыг давтан зохион байгуулах	+	+	+	+	+	Ёс зүйн хэсгийн хороо	
4.5	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага дээр гарч байгаа нийтлэг алдааг эмч мэргэжилтэнд таниулах зорилгоор тасаг нэгжүүд дунд жүжиглэсэн тоглолт зохион байгуулж алдаанаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах АСК	+					Ёс зүйн хэсгийн хороо	